



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар A/21

Баянхутаг

Хариуцлагатай жижүүр томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, ЭМС-ын 2019 оны А/611, ЭМС-ын 2020 оны 1 дүгээр сарын 29-ний А/36 тоот, ЭМС-ын 1а/728 албан тоот, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.2 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сар шинийн амралтын өдрүүдэд Эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй чанартай үзүүлж Эх барих, хүүхэд, осол гэмтэл, хордлогын яаралтай бэлэн байдлыг хангах, аливаа санамсаргүй алдаа зөрчил гаргахаас сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллахыг хариуцлагатай жижүүр эмч, сувилагч жолооч нарт даалгасугай.
2. Байгууллагын хариуцлагатай жижүүрийн нэрс, ажил үүргийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд ажиллаж байгаа хариуцлагатай жижүүртэй холбогдох мэдээг ээлжийн сувилагч тогтмол өгөх, эмч ажилчид утсаа байнга нээлттэй байлгахыг үүрэг болгосугай.

/Хавсралт 1хуудастай/

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Р.БАЛЖИННЯМ